



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар A/49

Улаанбаатар хот

МУБИС-д багц цаг дүйцүүлэн
тооцох журам батлах тухай

Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2024 оны А/216 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журам”-ын 1.1 дэх заалт, “МУБИС-ийн дүрэм”-ийн 4.6.2, 4.6.8, МУБИС-ийн “Ректорын зөвлөл”-ийн 2024 оны 12 дугаар сарын 27-ны хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУБИС-д багц цаг дүйцүүлэн тооцох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан МУБИС-ийн захирлын 2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/154 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “МУБИС-д хичээл дүйцүүлэн тооцох журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

РЕКТОР



Ж.БАТБААТАР

МУБИС-д багц цаг дүйцүүлэн тооцох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. “Сургалтын агуулгын багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журам” (БШУ-ы сайдын 2024 оны А/216 дугаар тушаал), “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журам” (БШУ-ы сайдын 2024 оны А/144 дугаар тушаал), “Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага” (БШУ-ы сайдын 2024 оны А/147 дугаар тушаал), “МУБИС-ийн бакалаврын сургалтын журам”, “МУБИС-ийн ахисан түвшний сургалтын үйл ажиллагааны журам” (МУБИС-ийн захирлын 2023 оны А/165 дугаар тушаал), “МУБИС-ийн суралцагчийг үнэлэх журам” (МУБИС-ийн захирлын 2024 оны А/322 дугаар тушаал) болон бусад холбогдох дүрэм, журмыг үндэслэл болгоно.
- 1.2. Энэхүү журмын зорилго нь суралцагчийн өмнө судалсан хичээл, тэдгээрийн багц цаг, үнэлгээ мөн олон улсын хэлний шалгалтын оноог МУБИС-д дүйцүүлэн тооцоход оршино.
- 1.3. Тус журмаар МУБИС-ийн сургалтын үйл ажиллагаан дахь дараах харилцааг зохицуулна. Үүнд:
 - 1.3.1. Бакалавр (үндсэн хөтөлбөр, хөрвөх болон цуваа загвар) магистр, докторын хөтөлбөрт шилжин суралцахад суралцагчийн өмнө судалсан хичээлийг дүйцүүлэх;
 - 1.3.2. 1+2, 2+1, 2+2, 3+1 зэрэг гадаад, дотоодын их дээд сургуультай хамтарсан хөтөлбөрөөр суралцагчдын хичээл болон тэдгээрийн багц цаг, үнэлгээг дүйцүүлэх;
 - 1.3.3. Оюутан солилцооны хөтөлбөрөөр суралцагчдын бусад их, дээд сургуульд судалсан хичээл болон тэдгээрийн багц цаг, үнэлгээг дүйцүүлэх;
 - 1.3.4. Зэрэг ахиулах болон хөрвөх хөтөлбөрт элсэгчдийн өмнө судалсан хичээл болон тэдгээрийн багц цаг, үнэлгээг дүйцүүлэх;
 - 1.3.5. Бакалаврын хөтөлбөрт суралцагчдын олон улсын хэлний шалгалтын оноог гадаад хэлний хичээлтэй дүйцүүлэх;
 - 1.3.6. Шууд шалгалтаар хичээл тооцуулахтай холбоотой харилцаа тус тус багтана.
- 1.4. Дүйцүүлэлт хийхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 1.4.1. Суралцагч нь ижил түвшний мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад суралцсан байх;
 - 1.4.2. Суралцагч элсэлтийн болон суралцах хугацаанд хамаарах баримт бичгийн зөрчилгүй, зохих шалгуурыг хангасан байх;
 - 1.4.3. Дүйцүүлэлт хийх үйл ажиллагаа нь хэн нэгэнд давуу байдал үүсгэхгүй, дүрэм журмын хүрээнд, шударга, ил тод, үнэн зөв байх;

- 1.4.4. Дүйцүүлэлт хийх явцад суралцагчидтай хүндэтгэлтэй, ёс зүйтэй хандаж, тэднийг мэдээллээр бүрэн хангах;
- 1.4.5. Дүйцүүлэх боломжит бүх хувилбарыг тооцож, суралцагчдад суралцах боломж, нөхцөлийг санал болгож арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэх;
- 1.4.6. Дүйцүүлэлт хийх хугацаа, хуваарь, үйл ажиллагааны аргачлал, дараалал тодорхой, нээлттэй байх;

Хоёр. Хичээл дүйцүүлэхэд тавих үндсэн шаардлага

- 2.1. Дараах их, дээд сургуулийн хичээлийг дүйцүүлэн тооцно. Үүнд:
 - 2.1.1. Байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаатай дотоодын их, дээд сургууль;
 - 2.1.2. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаатай, эсвэл олон улсын нэр хүнд бүхий ижил түвшний мэргэжилтэн бэлтгэдэг гадаадын их, дээд сургууль;
 - 2.1.3. Хамтын ажиллагааны гэрээтэй гадаад, дотоодын их, дээд сургууль тус тус хамаарна.
- 2.2. Хичээл дүйцүүлэхдээ албан ёсны баталгаажсан дүнгийн тодорхойлолт болон дипломыг үндэслэх бөгөөд дүйцүүлэх хичээлийн дүн 60 болон түүнээс дээш үнэлгээтэй, ахисан түвшинд 70 болон түүнээс дээш үнэлгээтэй, агуулгын хувьд суралцахуйн үр дүнгийн 80-аас доошгүй хувийн давхцалтай байх ба дараах шаардлагуудыг хангасан тохиолдолд дүйцүүлнэ. Үүнд:
 - 2.2.1. Дүйцэх хичээл өмнөх залгамж холбоогүй, эсвэл өмнөх залгамж холбооны хичээлийг амжилттай судалсан байх;
 - 2.2.2. Багц цагийн зөрүүгүй байх;
 - 2.2.3. Ижил түвшний хөтөлбөрүүдэд тусгагдсан байх;
 - 2.2.4. Цааш үргэлжлүүлэн суралцахад бэрхшээл учруулахгүй байх;
 - 2.2.5. Ахисан түвшний хөтөлбөрт гадаадын иргэн монгол хэлээрх хөтөлбөрт шилжин суралцах бол монгол хэлний түвшин тогтоох TOPMON шалгалтыг 3 ба түүнээс дээш түвшний оноотой байх, англи хэлээрх хөтөлбөрт шилжин ирж суралцах бол олон улсын англи хэлний шалгалтын B2 түвшний оноотой байх;
- 2.3. МУБИС-д хичээл дүйцүүлэх хувь хэмжээний дээд хязгаарыг Хүснэгт-1-д үзүүлснээр дараах байдлаар тогтооно.

Хүснэгт 1. МУБИС-д хичээл дүйцүүлэн тооцох хувь хэмжээний дээд хязгаар

1	Бакалаврын сургалт		Ерөнхий суурь	Багш боловсролын суурь (Мэргэжлийн суурь)	Мэргэжлийн хичээл
1.1	Хөрвөх, цуваа загвар	Багш - багш /мэргэжлийн өөр чиглэлд хөрвөх/	100%	100%	30%
1.2		Багш бус-багш /математикчаас математикийн багш гэх мэт/	100%	30%	70%

1.3	Өөр мэргэжил - багш /сэтгүүлчээс математикийн багш гэх мэт/	100%	20%	20%
1.4	Бакалаврын хөтөлбөрт шилжин суралцах	100%	70%	50%
1.5	2+2 зэрэг хамтарсан хөтөлбөр	50%	50%	50%
1.6	Бакалаврын хөтөлбөрт суралцагч шууд шалгалтаар тооцуулах хичээл (тус журмын 2.7 дахь заалт)	30%		
1.7	Бакалавр болон магистрын багц цагаас дүйцүүлэх	30%		
2	Ахисан түвшний сургалт	Мэргэжлийн суурь хичээл	Мэргэших хичээл	Сонгон суралцах хичээл
2.1	Магистр (шилжин ирэх)	Гадаадаас (6 кр)	30%	30%
2.2		Дотоодоос (6 кр)	20%	30%
2.4	Доктор	Гадаадаас (9 кр)	30%	30%
2.5	(шилжин ирэх)	Дотоодоос (9 кр)	20%	30%

2.4. Хөрвөх хөтөлбөрт элсэгч хичээл дүйцүүлэлт хийх үед хүсэлт гарган сургалтын төлөвлөгөөний хичээлүүдээс судлах шаардлагагүй гэж үзвэл шууд шалгалтаар тооцуулж болно.

2.5. Шууд шалгалтаар тооцох хичээлийн жагсаалтыг тухайн мэргэжлийн хөтөлбөрийн дэд хороо хэлэлцэн Хүснэгт 2, 3-ын дагуу тогтоож бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн албаар баталгаажуулан харгалзах Сургалт, цахим шилжилтийн хэлтэс, Ахисан түвшний хөтөлбөрийн албанд ирүүлнэ.

Хүснэгт 2. Шууд шалгалтаар тооцуулах хичээлийн жагсаалт

№	Сургууль, тэнхимийн нэр	Оюутны код	Овог, нэр	Хичээлийн код, нэр	Багшийн нэр	Кредит үнэлгээ	Шууд шалгалтын 35%-ийн дүн
1							

Хүснэгт 3. Ахисан түвшний хөтөлбөрийн шууд шалгалтаар тооцуулах хичээлийн жагсаалт
Сургууль, тэнхимийн нэр:.....
Хөтөлбөрийн нэр, код:.....

№	Суралцах хөтөлбөр	Мэргэжлийн ерөнхий суурь	Мэргэших хичээл
1	Магистрын хөтөлбөрт суралцагч	Хичээл – 1 Хичээл – 2	Хичээл – 1 Хичээл – 2
2	Докторын хөтөлбөрт суралцагч	Хичээл – 1 Хичээл – 2	Хичээл – 1 Хичээл – 2

- 2.6. Шууд шалгалт өгөх элсэгчийн нэр, хичээл бүхий захиалгыг бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн алба нэгтгэн Сургалт, цахим шилжилтийн хэлтэст ирүүлнэ. Шалгалтыг улирал бүрийн 4 дэх долоо хоногт танхимаар Сургалт, цахим шилжилтийн хэлтэс, Ахисан түвшний хөтөлбөрийн алба зохион байгуулна.
- 2.7. Бакалаврын хөтөлбөрт суралцагч нь шууд шалгалтаар хичээл дүйцүүлж болно. Энэ тохиолдолд тухайн улирлын хичээл Сонголт-2 хийхийн өмнө харьяа хөтөлбөрийн албанд мэдэгдэж бүртгүүлсэн байна. Шалгалтыг тус журмын 2.6-д заасны дагуу зохион байгуулна.
- 2.8. Суралцаж буй мэргэжлээр ЕБС, СӨББ-д 10-аас дээш жил багшилсан бол мэргэжлийн дадлагыг дүйцүүлэн тооцуулж болно. Энэ тохиолдолд дадлагын төлбөрийн 35%-ийг төлнө.
- 2.9. Шууд шалгалтаар тооцуулах хүсэлт гаргасан бол шалгалтын зардал болох тухайн хичээлийн нийт багц цагийн төлбөрийн 35%-ийг төлнө.
- 2.10. Хэрэв шалгуулагч хангалтгүй дүн үзүүлсэн бол шалгалтын төлбөрийг буцаахгүй бөгөөд тухайн хичээлийг судална.
- 2.11. Багш мэргэжлийн сонгон бүлэгт судалсан хичээлийг дүйцүүлэн тооцож болно. Энэ тохиолдолд суралцагч МУБИС-д элсэн суралцах болзлыг хангасан байна.
- 2.12. МУБИС-ийн монгол хэлний бэлтгэлд суралцсан гадаад оюутан хөтөлбөрт элсэн суралцах тохиолдолд бэлтгэл хөтөлбөрт судалсан хичээлийг элссэн хөтөлбөрт дүйцүүлэхгүй.
- 2.13. Төгсөгч нь дараагийн шатны сургалтад элсэн суралцах тохиолдолд хоёр түвшинд зэрэг судалдаг хичээлүүдийг дүйцүүлэн тооцно. Магистр, докторын хөтөлбөрт 12 хүртэлх багц цагийн мэргэжлийн суурь хичээлийг хамт судалж дүйцүүлж болно.
- 2.14. Сургууль хооронд шилжин суралцах суралцагчийн хичээлийг дүйцүүлэхдээ бакалаврын түвшинд ижил түвшний хөтөлбөрүүдэд тусгагдсан, дүйцэх хөтөлбөрийн Ерөнхий суурийн болон Мэргэжлийн суурийн, ахисан түвшинд ижил түвшний хөтөлбөрүүдэд тусгагдсан, дүйцэх хөтөлбөрийн Мэргэжлийн суурийн болон Мэргэших хичээлийн багцад тусгагдсан хичээлүүдээс дүйцүүлнэ. МУБИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцагчийн хичээл дүйцүүлэх тохиолдолд энэхүү хязгаарлалтыг мөрдөхгүй.
- 2.15. Сургууль хооронд шилжин суралцагчийн өмнө судалсан хичээлүүдээс бакалаврын хөтөлбөрт бол 45 хүртэл, магистрын хөтөлбөрт бол 6 хүртэл, докторын хөтөлбөрт бол 9 хүртэл багц цагийн хичээлийг дүйцүүлэн тооцож болно. МУБИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцагчийн хичээл дүйцүүлэх тохиолдолд энэхүү хязгаарлалтыг мөрдөхгүй.
- 2.16. Дэлхийн шилдэг 1000-д эрэмбэлэгдсэн их, дээд сургууль (THE)-д судалсан, журмын 2.1 ба 2.2-д тусгагдсан шаардлагыг хангаж буй хичээлийг дүйцүүлэхдээ журмын 2.14-д тусгагдсан багцын хязгаарлалтыг мөрдөхгүй байж болох ба магистрын хөтөлбөрт 10, докторын хөтөлбөрт 20 хүртэл багц цагийг тооцож болно.

- 2.17. Бакалавр-магистрын болон магистр-докторын нэгдмэл агуулга бүхий хөтөлбөрөөр суралцагчийн хувьд тухайн нэгдсэн хөтөлбөрт хоёр түвшинд зэрэг тооцож болохоор тусгасан хичээлийг харгалзах түвшний хөтөлбөрүүдэд шууд тооцно. Бакалавр-магистрын нэгдмэл агуулга бүхий хөтөлбөрт бакалаврын мэргэших болон магистрын мэргэжлийн суурь, мэргэших хичээлд 15 хүртэл багц цаг, магистр-докторын нэгдмэл агуулга бүхий хөтөлбөрт магистр, докторын мэргэжлийн суурь, мэргэших хичээлд 19 хүртэл багц цагийг тооцож болно.
- 2.18. Төгсөгч ижил түвшний хөтөлбөрт дахин элсэн суралцах тохиолдолд ерөнхий суурийн агуулгыг бүрэн хангасанд тооцож багц цагийн хэмжээг суралцах хөтөлбөрийн ерөнхий суурийн багц цагийн нийлбэр хэмжээгээр тооцно. Төгсөлтийн баримт бичигт “Өмнөх зэргийн хөтөлбөрөөс дүйцүүлэв” тэмдэглэгээ хийж, “тооцов” үнэлгээгээр дүгнэнэ. Ерөнхий суурийн багц цагийн зөрүү үүссэн тохиолдолд зөрүү багц цагийг нэмж судална. Энэ тохиолдолд уг журмын 2.13-2.15-д тусгасан хязгаарлалтыг мөрдөхгүй.
- 2.19. Төрийн өмчийн их сургуулиудын хичээл солилцооны хүрээнд судалсан, журмын 2.1, 2.2-т заасан шаардлагыг хангасан хичээлийг шууд дүйцүүлэх ба журмын 2.13-2.15-д заасан хязгаарлалтыг мөрдөхгүй.
- 2.20. Хамтын ажиллагааны гэрээний дагуу урьдчилан зөвшөөрөгдсөн зэргийн (багшийн туслах, туслах багш, багшлах эрхийн сургалт) болон зэргийн бус (иргэний гэрээгээр суралцах болон багшлах эрхийн сургалт) хөтөлбөрийн хичээлийг дүйцүүлж болно.
- 2.21. Үндсэн бус суралцагч зэргийн сургалтын хөтөлбөрийн хичээлийг амжилттай судалсны дараа зэргийн хөтөлбөрт элсэх тохиолдолд тухайн хичээлийг дүйцүүлэн тооцно.
- 2.22. Гадаадын их, дээд сургуультай хамтран хэрэгжүүлдэг хамтарсан болон хос зэрэг олгодог зэргийн хөтөлбөрүүдийн дагуу суралцаж ирсэн суралцагчийн багц цагийг хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай албан ёсны баримт бичигт заасан бол шууд дүйцүүлнэ. Суралцагч эдгээр хөтөлбөрөөр суралцахаар явах үед суралцахуйн гэрээнд үзэх хичээл болон түүнийг дүйцүүлэх хичээлүүдийг заавал тусгасан байна.
- 2.23. Гадаадын шилдэг дээд боловсролын сургалтын байгууллага (THE)-д хүлээн зөвшөөрөгддөг олон улсын шалгалтын үнэлгээг бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурийн ижил чиглэлийн хичээлүүдтэй дүйцүүлэн тооцож болно. Ингэхдээ тухайн ерөнхий суурь хичээлийг заадаг мэргэжлийн тэнхимийн шийдвэрийг үндэслэнэ.
- 2.24. Бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрт тусгасан гадаад хэлний 30 хүртэлх багц цагийн хичээлийг тухайн гадаад хэлээр боловсрол эзэмшсэн байдал, эсхүл хэлний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын онооны 60-аас дээш хувийн гүйцэтгэл, эсхүл сургуулиас тогтоосон шалгалтыг өгч тэнцсэн тохиолдолд дүйцүүлэн тооцож болно.
- 2.25. Журмын 2.23-д заасан дүйцүүлэлтийг хийхдээ тухайн гадаад хэлээр боловсрол эзэмшсэнийг нотлох баримт бичиг, олон улсын шалгалт өгсөн тухай албан ёсны батламж, шалгалтын материалыг хавсаргана.

- 2.26. Журмын 2.23-д заасан үндэслэлээр ахисан түвшний хөтөлбөрийн хичээлийг дүйцүүлэхгүй.
- 2.27. Дэд бакалаврын болон бакалаврын түвшний ерөнхий суурийн болон мэргэжлийн суурийн хичээлийн хувьд өмнөх мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн үнэлгээ хийж дүйцүүлэн тооцож болно. Энэ тохиолдолд мэргэжлийн багш нарын бүрэлдэхүүнтэй шалгалтын комиссоос тухайн хичээлийн суралцахуйн үр дүнгийн 70-аас доошгүй хувийн үнэлгээ авсан байна.

Гурав. Хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа

- 3.1. Бүрээүний болон салбан сургуулийн ерөнхий суурийн болон багш боловсролын хичээлийн дүйцүүлэлтийг бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн албаны мэргэжилтэн, мэргэжлийн хичээлийн дүйцүүлэлтийг тухайн мэргэжлийн тэнхимийн эрхлэгч хийж, хөтөлбөрийн албаны дарга хянан, бүрэлдэхүүн, салбар сургуулийн хичээл дүйцүүлэлтийн комисс баталгаажуулж, Сургалт, цахим шилжилтийн хэлтэст хүргүүлнэ.
- 3.2. Ахисан түвшний мэргэжлийн суурь болон мэргэших хичээлийн дүйцүүлэлтийг бүрэлдэхүүний болон салбар сургуулийн мэргэжлийн тэнхимийн эрхлэгч хийж, хөтөлбөрийн албаны дарга хянан, бүрэлдэхүүн, салбар сургуулийн хичээл дүйцүүлэлтийн комисс баталгаажуулж, Ахисан түвшний хөтөлбөрийн албанд хүргүүлнэ.
- 3.3. Хичээлийн дүйцүүлэлтийг улирал бүрийн эхний 4 долоо хоногт багц цагийн нэгтгэлийн тушаал гарахаас өмнө хийж, баталгаажуулсан байна.
- 3.4. Хичээл дүйцүүлэлтийг энэхүү журмын Хавсралт 1, 2-ын "Хичээл дүйцүүлэлтийн хуудас"-ыг ашиглан хийнэ.
- 3.5. Багш мэргэжлийн хөрвөх хөтөлбөрт элсэгч СӨБ, ЕБС-д 2-оос дээш жил багшилж байгаа бол Мэргэжлийн удиртгал хичээлийг албан ёсны тодорхойлолтыг үндэслэн дүйцүүлж болно. Энэ тохиолдолд дүнг тухайн элсэгчийн багшилсан жил, сургалтын чиглэлээр гаргасан амжилт, хичээл заасан суралцагчдын сурлагын амжилт, чанарт үндэслэн Хөтөлбөрийн алба дүйцүүлнэ.
- 3.6. Суралцагч дүйцүүлэлтийг зөвхөн нэг удаа хийлгэх эрхтэй.
- 3.7. МУБИС-ийн Чанарын баталгаажилт, мониторингийн албанаас төгсөлт болохоос 1 улирлын өмнө бүрэлдэхүүний болон салбар сургуулийн хичээл дүйцүүлэлтэд мониторинг хийх бөгөөд алдаатай хийсэн дүйцүүлэлтийг цуцалж болно.
- 3.8. Хэрэв дүйцүүлэлтийг алдаатай хийсэн нь нотлогдвол буруутай этгээд МУБИС-ийн "Дотоод журам"-ын дагуу хариуцлага хүлээнэ.
- 3.9. Дүйцүүлэлт буруу хийгдсэн тохиолдолд суралцагч хичээлийг судална.
- 3.10. Суралцаж байгаа мэргэжлийн чиглэлээр олон улсын түвшний олимпиад, тэмцээн, шалгалтад гаргасан амжилтыг үндэслэн багц цагт тооцож болох ба энэ тохиолдолд багц цагийн хэмжээ нийт 6 багц цагаас хэтрэхгүй байна.
- 3.11. Дээд боловсролын сургалтын байгууллагын онцлогоос хамааран суралцагчийн судалгааны ажлын үр дүн, суралцаж байгаа мэргэжлийн

- чиглэлээр олон улсын тэмцээн, уралдаанд гаргасан амжилтыг багц цагт тооцож болно.
- 3.12. Дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа ахлах сургуулийн эсвэл багш сонгоны сургалтын хөтөлбөрт тусгагдан судалсан дэд бакалавр, бакалаврын ерөнхий суурийн болон мэргэжлийн суурийн зарим хичээлийг тухайн сургуулийн харгалзах хөтөлбөрт элсэн суралцсан тохиолдолд дүйцүүлж болно.
- 3.13. Өмнө суралцаж байгаад чөлөөлөгдсөн суралцагч чөлөөлөгдсөнөөс хойш 10 жилийн дотор тухайн сургуульдаа шинээр элсэн суралцах тохиолдолд өмнө нь амжилттай судалсан хичээлийг дүйцүүлэн тооцож болно.
- 3.14. Хичээл дүйцүүлэхдээ багц цагийн тодорхойлолт нь ижил хичээлийн багц цагийг хэвээр тооцох бөгөөд бусад /гадаад/ тохиолдолд тухайн сургуулийн сургалтын цагийн талаар албан ёсны тайлбар заавал шаардана. Энэ тохиолдолд тухайн багц цагийн тодорхойлолт дахь суралцагчийн ачааллыг энэхүү журмын багц цагийн ачааллын харгалзах үзүүлэлтэд шилжүүлэн тооцно.
- 3.15. Багц цагийн систем нь өөрөөр тодорхойлогдсон багц цагийг гадаадын их, дээд сургуульд түгээмэл хэрэглэгддэг ялгаатай багц цагийг хөрвүүлэх аргачлал /Хүснэгт 5/-ын дагуу шилжүүлэн тооцно.
- 3.16. Суралцагчийн судалсан хэд хэдэн хичээлийн нийлбэр багц цаг болон суралцахуйн үр дүн дүйцэх хичээлийн багц цаг, суралцахуйн үр дүнд хүрч байвал тухайн хичээлүүдийг нэгтгэн дүйцүүлж болно. Дүйцэх хичээлийн үнэлгээг дүйцүүлэх хичээлүүдийн багц цаг ба дүнгийн жигнэсэн дунджаар бүхэлчлэн тооцно.
- 3.17. Суралцагчийн судалсан нэг хичээл нь хэд хэдэн хичээлийн суралцахуйн үр дүнг хангасан, тэдгээр хичээлийн багц цагийн нийлбэрээс багагүй байгаа тохиолдолд тэдгээр хичээлийг тус тусад нь дүйцүүлж болох ба дүйцэх хичээл бүрийн үнэлгээ нь дүйцүүлэх хичээлийн үнэлгээтэй адилхан байна.
- 3.18. Хичээл дүйцүүлэхдээ өмнөх хичээлийн үнэлгээг өөрчлөхгүйгээр тооцно.
- 3.19. Суралцагчийн хичээлийн үнэлгээ нь МУБИС-ийн үнэлгээний систем (дүнгийн шатлал)-ээс өөр бол тухайн сургуулийн дүнгийн шатлалын тухай албан ёсны тайлбарт үндэслэх бөгөөд амжилттай дүнг 60-95 онооны завсарт харгалзуулах замаар шилжүүлэн тооцно. Хэрэв үнэлгээг багц цагийн нарийвчлалтай холбож, багц цагийг бууруулан тооцсон бол интервалын дээд оноог харгалзуулна.
- 3.20. Үнэлгээний систем өөрөөр тодорхойлогдсон үнэлгээг гадаадын түгээмэл хэрэглэгддэг үнэлгээний системийг хөрвүүлэн тооцох аргачлал /Хүснэгт 5/-ын дагуу хөрвүүлэн тооцно.
- 3.21. Үнэлгээ тодорхойгүй буюу хувьчилсан оноонд хувиргах боломжгүй хичээлийг "тооцов" гэж үнэлээд багц цагийн биелэлтэд тооцож дүйцүүлнэ.
- 3.22. Дүйцүүлэн тооцох дүн үнэлгээний системийн аль нэг интервалаар тодорхойлогдож байвал уг интервалын дундаж утгаар эцсийн үнэлгээг тогтооно.

- 3.23. Сургууль хооронд хичээл дүйцүүлэхдээ хувьчилсан оноогоор дүнг тодорхойлж, харгалзах үсгэн үнэлгээ, нэмэлт тэмдэглэгээ хэрэглэнэ.
- 3.24. Гадаад улсад боловсрол эзэмшсэн төгсөгчийн баримт бичгийг энэхүү журмын Хүснэгт 4 болон 5-т заасан аргачлалын дагуу дүйцүүлнэ.
- 3.25. Дэд бакалаврын зэрэгтэй төгсөгч (Коосен, урлагийн чиглэлийн шаталсан сургалттай мэргэжлийн сургууль хамаарна.) дээд боловсролын сургалтын байгууллагад ижил чиглэлээр бакалаврын сургалтын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах тохиолдолд 30 хүртэлх багц цагийн хичээл дүйцүүлж болно.
- 3.26. Техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцахад 30 хүртэлх багц цагийг дүйцүүлэн тооцож болох ба дүйцүүлэх хичээлийн агуулга, багц цагийн хэмжээг сургууль өөрийн дотоод журмаар зохицуулна.

Хүснэгт 5. Гадаадын их, дээд сургуулиудад түгээмэл хэрэглэгддэг ялгаатай багц цагийг хөрвүүлэх аргачлал

Монгол	ECT8	АНУ*	БНХАУ	Энэтхэг	Япон	БНСУ	ОХУ**	Австрали	Канад	Сингапур
1 багц цаг	2	1	1	1	1	1	2	2	0.17	1.6

* Улирлын (quarter) багц цагт суурилсан багц цаг системтэй сургууль бол багц цагийг 3/2 коэффициентод хувааж тооцно.

** Багц цагаар хэмжигддэггүй, танхимын цагаар тодорхойлогддог сургалтын системтэй бол 72 танхимын цагийг 1 багц цаг гэж үзнэ.

Дөрөв. Багц цаг шилжүүлэн тооцох

- 4.1. Дотоодын болон гадаадын багц цаг ижил тодорхойлогдсон их, дээд сургуулийн багц цагийн хэмжээг шууд тооцох бөгөөд өөрөөр тодорхойлогдсон багц цагийг шилжүүлэхдээ тухайн сургуулийн албан ёсны тайлбарыг үндэслэн Хүснэгт 1-ийг баримтлан хийнэ.
- 4.2. Суралцагчийн судалсан хичээлийн багц цаг нь МУБИС-ийн харгалзах хичээлийн багц цагаас зөрүүтэй бол дараах байдлаар шийднэ. Үүнд:
 - 4.2.1. Тухайн хичээлийн суралцахуйн үр дүн нь МУБИС-тай ижил эсвэл 80 хувийн давхцалтай, багц цагийн зөрүү 1-ээс ихгүй тохиолдолд дутуу багц цагийн төлбөрийг төлүүлэн шууд дүйцүүлж болно.
 - 4.2.2. Хэрэв 1-ээс их багц цагийн зөрүүтэй бол дутуу багц цагийн төлбөрийг төлүүлэн шууд шалгалтаар тооцуулж болно. Энэ тохиолдолд тус журмын 2.6 болон 2.9 дэх заалтыг мөрдлөг болгоно.
 - 4.2.3. Багц цаг илүү байгаа тохиолдолд МУБИС-ийн дүйцэгдэх хичээлийн багц цагаар тооцно.
- 4.3. Суралцагчийн судалсан хэд хэдэн хичээлийн багц цаг болон суралцахуйн үр дүн нь МУБИС-ийн дүйцэх хичээлийн багц цаг, суралцахуйн үр дүнд хүрч байгаа тохиолдолд дүйцүүлэлтийг уг журмын 3.16-г баримтлан хийнэ.
- 4.4. Суралцагчийн судалсан нэг хичээл нь МУБИС-ийн хэд хэдэн хичээлийн суралцахуйн үр дүнг хангасан, тэдгээр хичээлүүдийн багц цагийн нийлбэрээс багагүй байгаа тохиолдолд дүйцүүлэлтийг уг журмын 3.17-г баримтлан хийнэ.

Тав. Суралцагчийн үнэлгээ буюу дүнг дүйцүүлэн тооцох

- 5.1. Дотоодын их, дээд сургуулиудын дүн, хуучин үнэлгээний системийг хөрвүүлэн тооцохдоо сургуулийн тайлбарыг үндэслэх ба БШУ-ы сайдын 2024 оны А/144 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журам”-ын хувьчилсан оноог үндэслэнэ.
- 5.2. Хуучин үнэлгээг “Онцсайн”, “Онц” эсвэл 5 бол 100, “Сайн”, 4 бол 89, “Дунд”, 3 бол 79, “Муу”, 2 бол 59 хувьчилсан оноонд хөрвүүлэн тооцох аргачлалыг диплом нөхөн олгох, хөрвөх болон зэрэг ахиулах хөтөлбөрт элсэгчдийн дүнг шилжүүлэн тооцоход хэрэглэнэ.
- 5.3. “Хангалттай”, “Тооцов”, “Тэнцэв” гэсэн үнэлгээнүүдийг хөрвүүлэхдээ “МУБИС-ийн суралцагчийг үнэлэх журам”-ын Хавсралт 2-т буй CR нэмэлт тэмдэглэгээ тавьж, голч тооцохгүй.
- 5.4. Гадаадын их, дээд сургуульд хэрэглэгддэг үнэлгээний системийг Хүснэгт 2-ын дагуу тооцно. Хүснэгт 4-т ороогүй үнэлгээг тухайн сургуулийн тайлбарыг үндэслэн дүйцүүлнэ.
- 5.5. Дүйцүүлсэн хичээлд CR нэмэлт тэмдэглэгээ хийнэ (“МУБИС-ийн суралцагчийг үнэлэх журам”-ын Хавсралт 2). Голч дүн нь МУБИС-ийн харгалзах дүн байна.

Зургаа. Гадаад хэлний шалгалтын оноог дүйцүүлэн тооцох

- 6.1. Бакалавр, магистр, докторын суралцагч олон улсын хэлний шалгалт /IBT TOEFL, IELTS, TPКИ, HSK, TOPIK, JLPT /-ыг 60 буюу түүнээс дээш хувьтай өгсөн шалгалтын онооны хугацаа хүчинтэй байгаа тохиолдолд сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурийн гадаад хэлний харгалзах заавал болон сонгон судлах хичээлийн аль нэгтэй дүйцүүлж болно.
- 6.2. Гадаад хэлний мэргэжлээр суралцаж буй бакалаврын оюутнууд тухайн хэлнийхээ олон улсын шалгалтад Хүснэгт 6-д буй оноог авсан бол мэргэжлийн хичээлүүдээс 6 хүртэл багц цаг дүйцүүлэн тооцож болно.

Хүснэгт 6. Дүйцүүлэлт хийх олон улсын шалгалтын онооны босго.

CEFR	IELTS /9.0/	TOEFL /120/	TOEIC /1390/	TPКИ	JLPT	TOPIK	HSK	TestDaf
C2 /Мэргэжлийн/	8.5-9.0	*	*	TPКИ 4	N1	TOPIK II (Level 6)	HSK 6	*
C1 /Гүнзгий/	7.0-8.0	95-120	1305-1390	TPКИ 3	N2	TOPIK II (Level 5)	HSK 5	TDN 5
B2 /Ахисан дунд/	5.5-6.5	72-94	1095-1304	TPКИ 2	N3	TOPIK II (Level 4)	HSK 4	TDN 3-4
B1 /Дунд/	4.0-5.0	42-71	790-1094	TPКИ 1	N4	TOPIK II (Level 3)	HSK 3	

- 6.3. Энэхүү журмын 6.1 болон 6.2-т заасан дүйцүүлэлтийг гадаад хэлний мэргэжлийн тэнхим хийж, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн албаны дарга хянан баталгаажуулах бөгөөд нотлох баримтыг хавсаргасан байна. Мэргэжлийн тэнхим нь хичээл дүйцүүлэлт болон дүнгийн тодорхойлолтыг энэхүү журмын Хавсралт 3-ын "Гадаад хэлний шалгалтын оноог дүйцүүлэн тооцох хуудас"-ыг ашиглан хийж суралцагчийн харьяа хөтөлбөрийн албанд хүлээлгэн өгнө.

Хавсралт 1.

ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭЛТИЙН ХУУДАС /БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР/

Огноо:

Хүсэлт гаргагчийн овог нэр:
Сурч байсан/өгссөн сургууль:
Суралцах хөтөлбөр:
Өмнөх боловсролын зэрэг/дипломын №:
Оюутны код:

Шилжиж ирсэн бакалаврын суралцагч
Бакалаврын хөтөлбөрт суралцагч
Хөрвөх хөтөлбөрт суралцагч
Хамтарсан хөтөлбөрт суралцагч

Хичээлийн код	МУБИС-ийн Сургалтын төлөвлөгөөний хичээл		Дүйцүүлэх хичээл				Шалгалтаар тооцуулах		Судлах хичээлийн	
	Хичээлүүд	Багц цаг	Хичээлийн нэр	Багц цаг	Хувьч. оноо	Үсгэн үнэлгээ *	Хичээлийн нэр	Багц цаг	Нэр	Багц цаг
	I. ЕРӨНХИЙ СУУРЬ									
	Заавал суралцах хичээл									
	Сонгон суралцах хичээл									
	II. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ									
	Заавал суралцах хичээл									
	Сонгон суралцах хичээл									
	III. МЭРГЭЖЛИЙН									
	Заавал суралцах хичээл									
	Сонгон суралцах хичээл									
	НИЙТ БАГЦ ЦАГ									

*Тайлбар: 1-3 баганад МУБИС-ийн сургалтын төлөвлөгөөнд заасан бүх хичээл, тэдгээрийн код, багц цагийг бичнэ.

* Тайлбар: "МУБИС-ийн суралцагчийг үнэлэх журам"-ын Хавсралт 2-т буй нэмэлт тэмдэглэгээ CR гэж байна.

Дүйцүүлэлт хийсэн:.....Хөтөлбөрийн албаны мэргэжилтэн

.....Тэнхимийн эрхлэгч

Зөвшөөрсөн: Өргөдөл гаргагч

Шалгасан: Хөтөлбөрийн албаны дарга

Хянасан: Хичээл дүйцүүлэлтийн комиссын дарга

Хавсралт 2.

ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭЛТИЙН ХУУДАС /АХИСАН ТҮВШНИЙ ХӨТӨЛБӨР/

Огноо: Шилжиж ирсэн магистрын суралцагч
Хүсэлт гаргагчийн овог, нэр: Шилжиж ирсэн докторын суралцагч
Сурч байсан/төгссөн сургууль: Хамтарсан хөтөлбөрт суралцагч
Суралцах хөтөлбөр: Нэгдмэл агуулгатай хөтөлбөрт суралцагч
Өмнөх боловсролын зэрэг/дипломын №:
Оюутны код: 807702-45 8021053

Хичээлийн код	МУБИС-ийн сургалтын төлөвлөгөөний хичээл			Дүйцүүлэх хичээл			Судлах хичээлийн	
	Хичээлүүд	Багц цаг	Хичээлийн нэр	Багц цаг	Хувьч. оноо	Үсгэн үнэлгээ*	Нэр	Багц цаг
	I. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛ							
	Заавал судлах хичээл							
	Сонгон судлах хичээл							
	II. МЭРГЭШИХ ХИЧЭЭЛ							
	Заавал судлах хичээл							
	Сонгон судлах хичээл							
	НИЙТ БАГЦ ЦАГ							

*Тайлбар: Эхний 3 баганад МУБИС-ийн сургалтын төлөвлөгөөнд заасан бүх хичээл, тэдгээрийн код, багц цагийг бичнэ.

* Тайлбар: "МУБИС-ийн суралцагчийг үнэлэх журам"-ын Хавсралт 2-т буй нэмэлт тэмдэглэгээ CR гэж байна.

Дүйцүүлэлт хийсэн: Тэнхимийн эрхлэгч / /
Зөвшөөрсөн: Өргөдөл гаргагч / /
Шалгасан: Хөтөлбөрийн албаны дарга / /
Хянасан: Хичээл дүйцүүлэлтийн комиссын дарга / /

Хавсралт 3.

ГАДААД ХЭЛНИЙ ШАЛГАЛТЫН ОНООГ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ ХУУДАС



Огноо:

Бакалаврын хөтөлбөрт суралцагч

Хүсэлт гаргагчийн овог нэр:
Бүрэлдэхүүн сургууль:
Суралцаж буй хөтөлбөр:

МУБИС-ийн Сургалтын төвлөвлөгөөний хичээл						
Хичээлийн код	Хичээлүүд	Багц цаг	Хувьч. оноо	Багц цаг	Үсгэн үнэлгээ*	Голч дүн
	ЕРӨНХИЙ СУУРЬ ХИЧЭЭЛ					
	Заавал суралцах хичээл					
	Сонгон суралцах хичээл					
	МЭРГЭЖЛИЙН СУУРЬ					
	Заавал суралцах хичээл					
	Сонгон суралцах хичээл					
	МЭРГЭЖЛИЙН					
	Заавал суралцах хичээл					
	Сонгон суралцах хичээл					
	НИЙТ БАГЦ ЦАГ					

* Тайлбар: Сургалтын журмын 4.6.16-д заасны дагуу дүйцүүлсэн хичээлийн үсгэн үнэлгээ бүгд CR гэж байна.
* Жич: Энэхүү журмын 6.2-т заасны дагуу дүйцүүлэх мэргэжлийн хичээлийн дээд хэмжээ 6 кр байна.

Дүйцүүлэлт хийсэн: Тэнхимийн эрхлэгч
Зөвшөөрсөн: Өргөдөл гаргагч
Баталгаажуулсан: Хөтөлбөрийн албаны дарга

Хүснэгт 4 Гадаадын түгээмэл хэрэглэгддэг үнэлгээний системийг хөрвүүлэн тооцох аргачлал

Монгол	A				B				C				D				F			
	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
ECTS	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Хятад	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Тайван	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Орос	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
Япон	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Англи	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Ирланд	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Итали	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Бельги	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Франц	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Португал	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Дани	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Швейцар	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Голланд	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Литва	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Испани	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Румын	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Исланд	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Грек, Кипр	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Швейцар	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Болгар	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Польша(2)	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Унгар, Швед, Хорват	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
Финланд(1)	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5
MU	100	95	90	85	80	75	70	65	60	55	50	45	40	35	30	25	20	15	10	5

Норвег	1.6	1.7	1.8	1.9	2	2.1	2.3	2.5	2.6	2.7	2.8	2.9	3	3.3	3.5	4	4.1	4.5	5
Герман	1	1	1	1	2	2	2	2	3	3	3	3	4	4	4	4	5	5	6
Австри	1	1	1	1	2	2	2	2	3	3	3	3	4	4	4	4	5	5	5
Чех	1	1	1	1	2	2	2	2	2	2	2	3	3	3	3	3	4	4	4
Эстони	A	A	A	A	B	B	B	B	C	C	C	C	D	D	E	E	F	F	F
Мальт	A+	A	A	A	B+	B+	B	B	C+	C+	C	C	D+	D+	D	D	F	F	F
Өмнөд солонгос	A+	A	A	A-	B+	B	B	B-	D+	D	D	D-					F	F	F
Турк	AA	AA	AA	AA	BA	BA	BA	BA	BB	BB	CB	CB	CC	CC	DC	DD	F	F	F
Хонгконг, Энэтхэг	A	A	A	A	B	B	B	B	C	C	C	C	D	D	D	D	F	F	F
Словак	Exc A	Exc A	Exc A	Exc A	Vgood	Vgood	Vgood	Vgood	Good	Good	Good	Satis	Satis	Satis	Pass	Pass	Fail	Fail	Fail
				A	B	B	B	B	C	C	C	D	D	D	E	E	F	F	F
Словени	Exc A	Exc A	Exc A	Exc A	Vgood	Vgood	Vgood	Vgood	Good	Good	Good	Satis	Satis	Satis	Pass	Pass	Fail	Fail	Fail
				A	B	B	B	B	C	C	C	D	D	D	E	E	F	F	F
Сингапур	Class I	Class I	Class I	Class II	Class II	Class II	Class II	Class II	Class III	Class III	Class III	Class III							